



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/17

Мандалговь

"Хүүхдийн төлөө аймгийн зөвлөл"-ийн
гишүүдийг чадавхижуулах сургалт
зохион байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 16.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23, 27 дугаар хамтарсан тушаалын 3 дугаар хавсралт, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.7 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр орон нутгийн түвшинд хүүхдийн төлөө шийдвэр гаргах, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа, зохицуулалтыг хангах, хүүхдэд ээлтэй засаглалыг төлөвшүүлэх зорилгоор зохион байгуулж буй Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсугай.

2. "Хүүхдийн төлөө аймгийн зөвлөл"-ийн гишүүдийг чадавхижуулах сургалтыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, сургалтын хөтөлбөрийг 2 дугаар, шаардагдах зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 823,300 (Найман зуун хорин гурван мянга гурван зуу) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй

4. Сургалтыг чанартай зохион байгуулж, хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг)-т даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ

№ 482201031

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 01 дугаар сарын 01 ний өдрийн
011 дугаар тушаалын 01 дугаар хавсралт

"ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ АЙМГИЙН ЗӨВЛӨЛ"-ИЙН ГИШҮҮДИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Цэцэг

(Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Гишүүд:

Ш.Эрдэнэсүвд

(Хүүхэд хамгаалал, залуучуудын асуудал
хариуцсан мэргэжилтэн)

Л.Мөнхсарнай

(Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан
мэргэжилтэн)

—oOo—

•

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 02 дугаар сарын 01 ний өдрийн
А/19 дугаар тушаалын 02 дугаар хавсралт

**"ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ АЙМГИЙН ЗӨВЛӨЛ"-ИЙН ГИШҮҮДИЙГ
ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Сургалтын зорилго:

Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр орон нутгийн түвшинд хүүхдийн төлөө шийдвэр гаргах, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа, зохицуулалтыг хангах, хүүхдэд ээлтэй засаглалыг төлөвшүүлэхэд оршино.

Хаана: Дундговь аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 209 тоот өрөөнд

Хэзээ: 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр

Зохион байгуулагч: Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

Сургагч багш: Х.Баавгай /доктор, дэд профессор, Монгол улсын гавьяат багш/

Оролцогчид:

- ✓ Хүүхдийн төлөө аймгийн зөвлөл-15
- ✓ Хүүхдийн хөгжил, хамгааллын алба-5

Сургалтын зохион байгуулалт	
08:40 - 09:00	Бүртгэл
09:00 - 09:15	Нээлт /ГБХЗХГазрын дарга Ц.Ганзориг/
09:15 - 09:30	Танилцах цаг
09:30 -09:40	Өмнөх үнэлгээ, хүлээлт тодруулах,
Сэдэв 1. Суурь ойлголт, хамтын ажиллагаа	
09:40-11:00	Хүүхдийн эрхийн тухай ойлголт, хүүхдийн үндсэн эрх
11:00-11:20	Цайны завсарлага
11:20-13:00	Хүүхэд хамгааллын талаарх үндсэн ойлголт, зарчим
13:00-14:00	Үдийн хоол
14:00-15:00	Хүүхдэд ээлтэй орон нутаг
15:00-16:00	Хүүхдийн эрхийг хангахад салбар дундын хамтын ажиллагаа
16:00-16:20	Цайны завсарлага
16:20-17:30	Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн чиг үүрэг зохион байгуулалт, анхаарах асуудал
17:30-18:00	Сургалтын дүгнэлт, хаалт <ul style="list-style-type: none">• Сертификат гардуулах

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 07 дүгээр сарын 01 ний өдрийн
117 дугаар тушаалын 01 дугаар хавсралт

**"ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ АЙМГИЙН ЗӨВЛӨЛ"-ИЙН ГИШҮҮДИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ
СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО**

№	Зардлын ангилал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Хэдэн удаа	Нийт үнэ
1	Сургагч багшийн хөлс	Хүн	20	40,000	8 цаг	320,000
2	Сургалтын танхимын хөлс	цаг	8	25,000	8 цаг	200,000
Цайны материал						
3	Сэндвич	ш	20	4,500	2	180,000
4	Ус	ш	20	780	2	31,200
5	Ундаа	ш	20	990	2	39,600
Сургалтын хэрэглэгдэхүүн						
6	Ажлын энгэрийн тэмдэг	ш	15	3,500	1	52,500
Нийт дүн						823,300

--- оОо ---